2026 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-09-15 Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 09 дүгээр сарын 22-ны “Мягмар” гарагийн 12:00 цагаас өмнө Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16:00 цагт** багтаан Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1	“Нийслэлийн хөгжлийн 2027 оны төлөвлөгөө”-ний төслийг НИТХ-аар хэлэлцүүлэхэд байгууллагын удирдлагууд идэвхтэй оролцох.	Засаг даргын Тамгын газар, Дүүргийн харьяа нийт байгууллагын удирдах албан тушаалтнууд
2	Гадаад харилцаанд нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам болон бусад байгууллагууд хамтран зохион байгуулах чадавхжуулах сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулах.	Батлан хамгаалах бодлогын шинэчлэл, үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Үндэсний аюулгүй байдал-иргэдийн оролцоо” үндэсний хөтөлбөрийн дагуу “Цогц батлан хамгаалах ба үндэсний сөрөн тэсвэрлэх стратегийг бүс орон нутагт хэрэгжүүлэх чадамжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтад дүүргийн ЗДТГ-ын нэг албан хаагчийг хамруулаад байна.
ТӨСӨВ САНХҮҮ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД		
3	Нийслэл, дүүргийн 2026 оны төсвийн тодотгол, 2027 оны төсвийн төслийг боловсруулах бэлтгэл ажлыг сайтар хангах.	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Дүүргийн харьяа нийт байгууллага
4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төсвийн зарцуулалтыг хэмнэлтийн горимд шилжүүлж, төсвийн орлогын гүйцэтгэлийн эрсдэлийг бууруулах, төсвийн сахилга батыг сайжруулах.	

ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
5	Замын хөдөлгөөний ачаалал нэмэгдэхтэй холбогдуулан хөдөлгөөний урсгалын судалгаа, тооцоонд үндэслэн ачаалал ихтэй уулзвар, замын хэсгүүдийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, гэрлэн дохионы ухаалаг зохицуулалтыг боловсронгуй болгох, сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах.	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг, Боловсролын хэлтэс, Боловсролын байгууллагууд
6	Сургуулийн автобусны үйлчилгээг яаралтай жигдрүүлж, маршрут, чиглэл, өглөө, өдөр, орой хичээл эхлэх болон тарах цагуудад үйлчлэх цагийн хуваарь зэргийг эцэг, эхчүүдэд нь тогтмол мэдээлж ажиллах.	Боловсролын хэлтэс, Боловсролын байгууллагууд
7	Авто зам, явган хүний замын засвар, шинэчлэлийн ажлыг стандартын дагуу гүйцэтгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
8	Захиалагчийн хяналт тавьж буй байгууллагууд хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанд чанар, стандартын дагуу гүйцэтгүүлэн, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Г.Одонбаатар, Захиалагчийн хяналт тавьж буй байгууллагууд
9	Нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ууд хөдөлмөрийн биржүүдтэй хамтран ажилгүй иргэдийг ажилд зуучлах нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, үр дүнг дүгнэж ажиллах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хороод
10	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд болон эмнэлгүүдийг бэлэн байдалд ажиллуулах, үйлчилгээний чанарыг дээшлүүлж, төрөлжсөн эмнэлгүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв
11	“Томуугийн эсрэг хамтдаа” уриан дор зорилтот бүлэгт чиглэсэн вакцинжуулалтыг эрчимжүүлэх.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв, Дүүргийн харьяа нийт байгууллага
12	“Шарилжгүй Улаанбаатар” аяны хэрэгжилтийг хангуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Хороод, Дүүргийн харьяа нийт байгууллага
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД		
13	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцыг нэгтгэж танилцуулах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Инженер хангамжийн байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
14	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2026 оны намрын улирлын “Мод тарих өдөр”-ийг дүүргийн хэмжээнд 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Дүүргийн харьяа нийт байгууллага

15	2 дугаар хорооны “Өрхийн эмнэлэг”-ийн баруун талд байрлах Улаан байшинг буулгах ажлыг зохион байгуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
16	“Өндөрлөг” орчмын машины хөдөлгөөний хязгаарлалт хийх, гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулах, нэмэгдүүлэх.	Багахангай тохижилт , Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ-ууд
17	Дүүрэгт “Хүүхдийн хоолны зөвлөл” байгуулах.	ЗДО Х.Цогцэцэг, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Боловсролын хэлтэс
18	Байгууллагын эцэг, эхийн зөвлөлөөр тухайн байгууллага орчмын эрсдэлийн үнэлгээ хийлгэх.	ЗДО Х.Цогцэцэг, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаллын хэлтэс
19	Хөлбөмбөгийн талбайн гүйлтийн замыг стандартад нийцүүлэх талаар судалж, шаардлагатай төсөв, тооцооллыг гарган танилцуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
20	“Алсын худаг”-ийг хамгаалалтад авах талаарх албан бичгийг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
21	Баруун жигүүрийн бохирын шугам шинэчлэх ажлыг яаралтай гүйцэтгэх.	Илч-Орд ОНӨААТҮГ
22	УБЦТС ТӨХК-ийн агаарын шугам шинэчлэх, тулгуур буулгах, кабель татах ажлыг зохион байгуулах.	Дүүргийн Менежер Г.Дагвадорж, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
23	Өндөрлөгийн “Street food”-ийн үйл ажиллагааг олгогдсон зөвшөөрөл, зориулалтын дагуу ажиллуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
24	Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк ХК-д нэн шаардлагатай Инженер мэргэжлээр сурч боловсрох хүсэлтэй иргэдийн судалгаанд үндэслэн ШУТИС-ийн холбогдох сургалтад хамруулж, болосвон хүчин бэлтгэх ажлыг зохион байгуулах.	ЗДО Х.Цогцэцэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв
25	Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх хүрээнд гарсан дүүргийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хангуулах.	Онцгой байдлын хэлтэс, Дүүргийн харьяа нийт байгууллага

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР